



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар 399

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, 21 дүгээр зүйлийн 6 дахь, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай.

1.1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 01/4123 дугаар албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/12140 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирлаар Ухнаагийн Баярбилэгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу томилж, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах.

2.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ